



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 65

Эрдэнэт

Ахмад настны "Ач санах" дэд  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 14.5.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан "Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.2.1 заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ахмад настны "Ач санах" дэд хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр гарган, шаардагдах төсөв, хөрөнгийг тухайн жилийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон нутгийн төсөвт тусган батлуулж, гадаад дотоодын төсөл хөтөлбөрүүдээс санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг хайх, биелэлтийн явцыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.



ДАРГА *[Signature]* П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100055